



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/299

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Фортис эмнэлгээс Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй 2017 оны 9 дүгээр сарын 27, Хавдар судлалын үндэсний төвтэй 2019 оны 3 дугаар сарын 13, “Интернэйшнл Медикал Сентер” ХХК-ийн “Интермед” эмнэлэгтэй 2017 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгох үйл ажиллагааг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

081119

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 06 сарын 21-ны өдрийн  
#1299 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Вивек Виж Vivek Vij	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг  Хавдар судлалын үндэсний төв  “Интернэйшнл Медикал Сентер” ХХК-ийн “Интермед” эмнэлэг	Бүгд Найрамдах Энэтхэг Улсын “Фортис” эмнэлэг	ГЭ0002321	Мэс засал судлал	Эмчлэх	2019.06.25-2019.06.26 2 хоног